

ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ

Б.ДОРЖТОГОО

[УЯНГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР]

Огноо: 2020.03.09

**[ЖАРГАЛАНТ БАГИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ХООЛ] НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ
АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Харьцуулалт/
гэрээний дугаар:**

Багц-2 ХА 2020/02/008
Багц-3 ХА 2020/03/008

Үнэлгээний хорооны дарга
Нарийн бичгийн дарга
Гишүүд

С.Саранцэцэг
Б.Энхбат
Ц.Оюунчулуун

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Засаг даргын Тамгын газар] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[Уянга сумын Жаргалант багийн цэцэрлэгийн хүүхдийн хоол]**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2020 оны 03-р сарын 23-ны өдрийн 18 цаг]**-аас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 03-р сарын 23]**-ны өдрийн **[18:30]**¹-т **[Уянга сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн албаны 102 тоот өрөөнд Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн Б.Энхбат, утас:94046226]** нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Тендерийн баримт бичгийн үнэ: 20000 төгрөг

[Уянга сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн албаны 102 тоот өрөөнд Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн Б.Энхбат, утас:94046226]

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах эрх
олгох тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [2-оос доошгүй] жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>Сүүлийн [2-оос доошгүй] туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>Бусад нэмэлт шаардлага; <i>/гэх мэт/.</i></p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: [тусгай зөвшөөрөлтэй байна.]</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: [Уянга сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн албаны Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн Б.Энхбат, утас:94046226]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: [1 давхар 102 тоот өрөө]</p> <p>Огноо: [2020 оны 03-р сарын 23-ны өдөр]</p> <p>Цаг: [18 цаг 00 минут]</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Уянга сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн албаны 102 тоот өрөөнд]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: [1 давхар 102 тоот өрөө]</p> <p>Огноо: [2019 оны 03-р сарын 23-ны өдөр]</p> <p>Цаг: [18 цаг 30 минут]</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц-2. Сүү, сүүн бүтээгдэхүүн /инпортын бус/, Багц-3 Бусад хүнсний бүтээгдэхүүн, Үүнд: Гурил, гурилан бүтээгдэхүүн /инпортын бус/, цөцгийн тос, элсэн чихэр, төмс, хүнсний ногоо, будаа, ургамлын тос, өндөг, жимс, жимсгэнэ.]</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- 1. Барааны тодорхойлолт: Багц-2. Сүү, сүүн бүтээгдэхүүнд** хуурай болон шингэн сүү, тараг, аарц хамаарна, **Багц-3. Бусад хүнсний бүтээгдэхүүн, Үүнд: Гурил, гурилан бүтээгдэхүүнд** бялуу, кекс хамаарахгүй, **төмс, хүнсний ногоонд** дарсан ногоо буюу лаазалсан, дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй, **будaa гэдэгт** бүх төрлийн будaa, хүүхдийн будaa, үр тариа, шар буурцгийн гаралтай бүтээгдэхүүн хамаарна, **жимс, жимсгэнэ гэдэгт** компот, хатаасан жимс хамаарахгүй, **бусад гэдэгт** давс, элсэн чихэр, ургамлын тос, масло, амтлагч, цай, исгэгч орно.]
Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуй нэгж /дэлгүүр/ нь:
 - Худалдааны газрын үйлчилгээ MNS 5021:2004 улсын стандартыг мөрдөж хэвшсэн байх
 - Үйлчилгээний зориулалтаар зохион байгуулсан худалдааны заалны хэмжээ 41 м2-аас багагүй байх
 - Шаардлага хангасан хүнсний агуулах, зориулалтын хөргөгч, хөргүүртэй байх
 - Үүдны хэсэгт тохижилт, гэрэлтүүлэгтэй энгийн хаяг тавьж зүлэгжүүлсэн байх
 - Жин хэмжүүр нь баталгаажсан, хугацаа дуусаагүй байх
 - Ариун цэвэр, ахуйн хангамжийн өрөө, халаалтын асуудлыг шийдсэн байх
 - Худалдаалж буй барааны нэр төрөл олон, сонголт их байх
 - Барааны баталгаажилт, шинжилгээний иж бүрдэлтэй байх
 - Худалдагч мэргэжлийн, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдсан эрүүл, ажлын хувцас, энгэрийн тэмдэг, нэрийн хуудсыг зүүж хэвшсэн байх зэрэг шаардлагууд, барааны эргэлт, санхүүгийн чадавхи зэргийг харгалзан үзнэ.
 - Байнгын татвар төлөгч байх
 - НӨАТ-ийн суутган төлөгчөөр бүртгэгдсэн Татварын гэрчилгээтэй байх
- 2. Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл *[Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа худалдааны газрын болон нийлүүлэх нэр төрлийн бүтээгдэхүүний тус бүрийн стандарт, мөн бүтээгдэхүүний тээвэрлэлт, сав баглаа боодлын стандартын шаардлага хангасан байна.]*
- 3. Бүтээгдэхүүн нь:** Мэргэжлийн хяналтын газрын үнэлгээ, дүгнэлттэй байх
- 4. Байгууллага, аж ахуй нэгж нь:** Ажлын байрны үнэлгээтэй байх
Е баримт хэвлэдэг машинтай байх
Баталгаажсан жин хэмжүүртэй байх
- 5. Баглаа, боодол:**
 1. *[Барааг хэлбэр хэмжээ, жин, ачиж буулгах, тээвэрлэх нөхцлийг цаг уурт харгалзуулан бат бөх, урагдаж эвдрэхгүй цэвэр нямбай савлаж бэлтгэн нийлүүлэх*
 2. *Нийлүүлэгдэх барааны чанар стандартыг бүрэн хангасан байх, бараа авдаг газрын тодорхойлолт, гарал үүслийн гэрчилгээг хавсаргах*
 3. *Буруу шошголсон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдаалаагүй байх*
 4. *Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгонд агуулагдах мэдээлэл монгол, орос, англи хэлний аль нэг дээр бичигдээгүй байх*
 5. *Худалдааны газар өөрөө жижиглэн савласан бол хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгын мэдээлэл нь шаардлага хангасан байх*
 6. *Хүнсний зориулалтын сав, баглаа боодолд савласан байх*
 7. *Зарим нэр төрлийн барааг хоёрдогч гуравдагч этгээдээс авч нийлүүлж байгаа бол хамтарлын гэрээний хуурбарыг хавсаргах]*
- 6. Бараа хүргэх газар:** [Жаргалант багийн цэцэрлэгт]
- 7. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Сүү, сүүн бүтээгдэхүүн	Импортын бус	4287	л	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Сүү	Шим	2144	л	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Сүү	Хайрцагтай	1440	л	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Өрөм	Шим	103	Кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Тараа	Шим	300	л	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Аарц	Шим	300	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Гурил, гурилан бүтээгдэхүүн	Импортын бус		Кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Гурил	1-р зэрэг	650		Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Гурил	2-р гурил	200		Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Гоймон	Кг-ын	60		Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Гоймон	Ширхэгийн	50		Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Печень	Цайны	600		Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Төмс, хүнсний ногоо	Эх орондоо үйлдвэрлэсэн төмс, хүнсний ногоо		Кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Төмс	Дотоод	200	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Байцаа	Дотоод	120	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Лууван	Дотоод	60	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Манжин	Дотоод	60	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Хүрэн манжин	Дотоод	40	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	

Сонгино	Дотоод	80	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Огурцы	Дотоод	80	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Сармис	Дотоод	20	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Помидор	Дотоод	40	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Өнгөт чинжүү	Дотоод	60	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Вандуй	650 гр Дотоод	10	ш	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Цэцэгт байцаа	Дотоод	80	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Будаа	Бүх төрлийн будаа, хүүхдийн будаа, үр тариа, шар буурцаг		Кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Цагаан будаа	Импорт	110	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Шар будаа	Импорт	80	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Гурвалжин будаа	Импорт	80	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Хүүхдийн будаа	Импорт	50	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Хөц будаа	Импорт	100	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Жимс, жимсгэнэ	Компод, жимсний чанамал, хатаасан жимс хамаарахгүй		Кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Чацарга на	Дотоод	50	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Үзэм	Дотоод	40	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Бусад	Давс, элсэн чихэр, ургамлын тос, масло, амтлагч, цай, исгээгч			Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Элсэн чихэр	Импорт	180	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Ургамлын тос	Дотоод	50	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Пүнтүүз	Импорт	40	ш	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	

Далайн байцаа	Импорт	100	ш	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Өндөг	Дотоод	95	ш	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Давс	Дотоод	60	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Исгээгч	Импорт	300	ш	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Хоол амтлагч	Дотоод	40	ш	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Майонез	Импорт	30	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Цай	Паккет	20	ш	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Цай	2 кг-ийн том	10	Ш	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Кетчуп	Дотоод	10	Ш	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Ёотон	0.5 грамм	20	ш	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	
Тахианы мах	Дотоод	50	кг	Багийн төв дотор	2020 оны 03-р сарын 01	2020 оны 12-р сарын 31	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [0] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [30] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Захиалагч нь гэрээ байгуулахаас өмнө шалгарсан дэлгүүрүүдээс нийлүүлэхээр санал болгосон бүтээгдэхүүн нь стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгаж, ямар үйлдвэрийн бүтээгдэхүүн нийлүүлэх талаар нэг бүрчлэн тохирох, мөн жагсаалтанд бүртгэлтэй бүтээгдэхүүн худалдаалж байгаа эсэх болон гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад байгууллагын нярав нар улирал тутам, мөн хэрэглэгчдээс гомдол, санал ирсэн тохиолдолд захиалагч ажлын хэсэг томилон хяналт шалгалт хийнэ.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Нийлүүлж байгаа бүтээгдэхүүний баталгаат хугацаа дуусаагүй байна]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[100]** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[0,5]**
- Алдангийн нийт дүн: **[10]**

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]